

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТ

АУДИТЫН КОД: СЭА-2024/12-17-НА-НА

АЙМГИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ 4,296.7 САЯ ТӨГРӨГӨӨР
НЭМЭГДҮҮЛСНЭЭС ШАЛТГААЛАН ТАТВАРЫН БУС БУСАД ОРЛОГЫГ 6,830.5 САЯ
ТӨГРӨГӨӨР ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР НЭМЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

Сүхбаатар сум 2024 он

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Утас: 70363047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Аудитор Д.Чулуунцэцэг

Утас: 70363047 Цахим хаяг: chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, зургийн товьёг	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн орлогыг хууль, эрх зүйн актад нийцүүлэн, нөөц боломжийг бүрэн ашиглаж, төлөвлөсөн эсэх?	6
1.1 Орон нутгийн төсвийн орлогыг хууль эрхийн актад нийцүүлэн үндэслэлтэй боловсруулж, төлөвлөсөн үү?	6
1.2 Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан уу?	7
БҮЛЭГ 2. Орон нутгийн төсвийн зарлагыг хууль, эрхийн актын хүрээнд арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх?	7
2.1 Орон нутгийн төсвийн зарлагыг хууль эрхийн актын хүрээнд үндэслэлтэй төлөвлөсөн үү?	8
2.2 Орон нутгийн төсвийн зарлагыг арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөсөн үү?	9
БҮЛЭГ 3. Төсөвлөлтийн шаардлага хангасан, зорилго, чиг үүрэгт нийцсэн төсөл, арга хэмжээг ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх?	10
3.1 Төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль эрхийн акт, чиг үүрэгт нийцүүлэн төлөвлөсөн үү?	10
3.2 Зорилго, чиг үүрэг болон хууль, эрх зүйн актад нийцсэн төсөл арга хэмжээг ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үү?	12
Тайлангийн хавсралтууд	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
БОГ	Байгаль орчны газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
УИХ	Улсын Их Хурал
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1	Аймгийн ОНХО-аар хэрэгжүүлэхээр төсөвлөсөн төсөл, арга хэмжээ	10
Хүснэгт 2	Зураг төсөв, тооцоо судалгаагүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээ	10
Хүснэгт 3	Улсын төсөвт хамаарах төсөл, арга хэмжээний жагсаалт	12
Хүснэгт 4	ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа	12
Хүснэгт 5	Зураг, төсвийг урьдчилан хийлгэлгүйгээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт	14

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 болон УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- *Орон нутгийн төсвийн орлогыг хууль, эрх зүйн актад нийцүүлэн, нөөц боломжийг бүрэн ашиглаж, төлөвлөсөн эсэх?*
- *Орон нутгийн төсвийн зарлагыг хууль, эрхийн актын хүрээнд арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх?*
- *Төсөвлөлтийн шаардлага хангасан, хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн зорилго, чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх?*

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж, ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд

заасан шаардлагыг шалгуур болголоо.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Сэлэнгэ аймгийн 2023, 2024 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл (батлагдсан болон урьдчилсан), УИХ-аас батлагдсан болон аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөл, холбогдох танилцуулга мэдээлэл, төсвийн орлого бүрдүүлдэг, аймгийн төсвөөс санхүүждэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээллийг хамруулан гүйцэтгэв.

Талуудын хүлээх үүрэг, хариуцлага:

Аймгийн Засаг дарга нь Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийг танилцуулгын хамт бэлтгэн, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дахь *“Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”* гэсэн заалтын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн аймгийн 2025 оны төсвийн төслийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Д.Чулуунцэцэг нар 2024 оны 11 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

УИХ-аас аймгийн татварын орлогыг 32,543.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,197.0 сая төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 10,637.1 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 31,299.0 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 94.8 сая төгрөгөөр тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг тус бүр 76,582.2 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга нь УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн орлого, зарлагыг тус бүр 4,296.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 80,878.9 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ХҮРЭЭНД ҮНЭН ЗӨВ ТООЦООГҮЙ БАЙНА

2.1 ТАТВАРЫН БУС БУСАД ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР 6,830.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН ТООЦСОН БАЙНА

1.1.1 УИХ-аас аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 32,543.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,197.0 сая төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 10,637.1 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 31,299.0 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 94.8 сая төгрөгөөр тус тус тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 76,582.2 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

1.1.2 Аймгийн Засаг дарга нь УИХ-аас батлагдаж ирсэн орлого, эх үүсвэрийг нийт 4,296.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 80,878.9 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна. */Дэлгэрэнгүйг хавсралт 1-т харуулав./*

Өөрчлөлт оруулж, төлөвлөсөн төсвийн орлого, эх үүсвэрийг нэр төрлөөр нь харуулбал:

- *Тэмдэгтийн хураамжийг 2,600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,000.0 сая төгрөгөөр,*
- *Татварын бус бусад орлогыг 6,830.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 7,830.5 сая төгрөгөөр,*
- *Орон нутгийн орлогын дансны үлдээгдлийг 1,000.0 сая төгрөгөөр тооцон,*
- *Сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 6,133.8 сая төгрөгөөр бууруулсан гэх мэт.*

1.1.3 Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т *“Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараах байдлаар төвлөрүүлнэ: 56.2.1: доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн ... 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.”* гэж заасан байдаг.

1.1.4 Дээрх заалтын дагуу сумдын 2025 оны төсвийн суурь орлого, зарлагыг тооцоолж, үндсэн тэнцлийн ашгаас 2025 онд Ерөө сумаас 762.8 сая төгрөг, Мандал сумаас 1,044.0 сая төгрөг, Сайхан сумаас 31.9 сая төгрөг, Сүхбаатар сумаас 2,493.3 сая төгрөг, Хүдэр сумаас 171.4 сая төгрөг зэрэг нийт **4,503.4** сая төгрөгийн / УИХ-аас 10,637.1 сая төгрөгөөр батлагдсан/ орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр бууруулан тооцсон байна.

1.1.5 Аймгийн төсвийн татварын бус орлогын бусад орлогыг УИХ-аас 1,000.0 сая төгрөгөөр баталж ирүүлсэн боловч зардлын нэмэгдлийг санхүүжүүлэх зорилгоор үндэслэлгүйгээр 6,830.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн **7,830.5** сая төгрөгөөр тооцсон нь төсвийн үнэн зөв байх зарчмыг алдагдуулсан байна.

1.1.6 Аймгийн 2024 оны 10 дугаар сарын төсвийн орлогын мэдээгээр татварын бус бусад орлого нь **534.7** сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу өргөн мэдүүлсэн орлогоос даруй 14 дахин бага байгаа нь дээрх орлого төсөвт төвлөрөх ямар ч боломжгүйг харуулж байна.

1.1.7 Гадаадын иргэн харьяатын газар нь Монгол Улсад түр ирэгч, дамжин өнгөрөгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хянах, бүртгэх, үйлчилгээ үзүүлсний хураамжийг Улсын тэмдэгтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасан хувь хэмжээгээр хурааж, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.3-д заасны дагуу аймаг, сумын төсвийн орлогод төвлөрүүлэхээр заасан байдаг.

1.1.8 Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газрын 2025 оны орлогын төлөвлөгөө болон 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн тэмдэгтийн хураамжийн орлогыг 2,600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн өргөн мэдүүлсэн байна.

1.1.9 Мөн орон нутгийн ерөнхий орлогын дансны 2025 оны эхний үлдэгдлийг **1,000.0** сая төгрөгөөр тооцон орлогыг нэмэгдүүлсэн байна.

1.2 ӨМНӨХ ОНУУДЫН ТАТВАРЫН ӨРИЙН ТОДОРХОЙ ХЭСГИЙГ БАРАГДУУЛСНААР ОРЛОГО НЭМЭГДЭХ НӨӨЦ БОЛОМЖИЙГ ТООЦООГҮЙ БАЙНА

1.2.1 Монгол Улсын жил бүрийн Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад “Татвар хураалт орлого бүрдүүлэлтийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлт”-ийн зорилтот түвшинг тооцохдоо өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалтыг 70 хувиар, төлөвлөж буй жилийн өмнөх жилийн татварын тайлангийн ногдол, өр барагдуулалтыг 80.0 хувиар тус тус тогтоож, төсвийн орлогыг төлөвлөсөн байдаг.

1.2.2 Гэтэл аймгийн төсвийн орлогыг дээрх эх үүсвэрээр нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцоогүй буюу өмнөх онуудын татварын дутуу төлөлтөөс үүссэн татварын өрийг барагдуулах талаар огт тусгаагүй байна.

1.2.3 2023 оны татварын өрийн үлдэгдэл 2,233.3 сая төгрөгөөр тайлагдсанаас 2024 онд 1,251.1 сая төгрөгийн өрийг барагдуулсан байна. Иймээс зөвхөн 2023 оны татварын өрийн үлдэгдэл 982.2 сая төгрөгөөс 70.0 хувийн өрийг барагдуулахаар тооцоход аймгийн төсвийн орлогыг **687.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх нөөц боломж байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БӨӨН ДҮНГЭЭР БОЛОН БАТЛАГДСАН ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ НЭМЭГДҮҮЛЭН, ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

2.1 УИХ-ААС БАТАЛСАН АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ НИЙТ 4,296.7 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БАЙНА

2.1.1 Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.2-т заасны дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудын 2025 оны төсвийн төслийг хүлээн авч, Сангийн Яамнаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу хянаж, төсвийн урсгал зардлыг төлөвлөсөн байна.

2.1.2 УИХ-аас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн 2025 оны төсвийн суурь зарлагыг 90,687.4 сая төгрөгөөр (*аймаг, сумдын*) баталсан байна.

2.1.3 Үүнээс аймгийн төсвийн суурь зарлагыг 30,137.5 сая төгрөгөөр (*урсгал зардал 21,300.5 сая төгрөг, хөрөнгө оруулалт 8,837.0 сая төгрөг*), аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 15,145.7 сая төгрөгөөр, ОНХС-ийн зарлагыг 31,299.0 сая төгрөгөөр зэрэг аймгийн нийт зарлагыг **76,582.2** сая төгрөгөөр баталсан байна.

2.1.4 Аймгийн Засаг дарга нь УИХ-аас баталсан 2025 оны төсвийн урсгал зардлыг нийт 4,296.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **80,878.9** сая төгрөгөөр төлөвлөн аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна. */Дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав./* Үүнд:

- *Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2.3 дахь хэсэгт “ Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусгаан шийдвэрлэж болно..” гэж заасны дагуу төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалин, НДШ-ийн зардлыг 1326.9 сая төгрөгөөр,*
- *Засаг даргын нөөц хөрөнгийг 410.0 сая төгрөгөөр,*
- *Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлыг 1,000.0 сая төгрөгөөр,*
- *Засаг даргын ерөнхий дансыг 316.5 сая төгрөгөөр /Гамшгаас хамгаалах арга хэмжээнд 40.0 сая төгрөг, улаан загалмай 70.0 сая төгрөг, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг 20.0 сая төгрөг, цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээнд 30.0 сая төгрөг, хүүхэд хамгааллын арга хэмжээнд 156.5 сая төгрөг гэх мэт/*
- *УИХ-аас батлагдсан орон тооны хязгаарыг 14-өөр нэмэгдүүлэн цалин, НДШ-ийн зардлыг 515.3 сая төгрөгөөр,*
- *Бусад зардлыг / Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах зардалд 205.0 сая төгрөг, төлөөлөгчдийн хурлын зардалд 127.4 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын тогтмол зардалд 602.0 сая төгрөг, тогтмол зардлын 2025 онд нэмэгдэх зардалд 183.3 сая төгрөг, урсгал засварт 80.0 сая төгрөг, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 75.0 сая төгрөг, уналга цугларалтад 40.0 сая төгрөг, төрийн албан хаагчийн мэргэшүүлэх зардалд 35.0 сая төгрөг, 4 албан хаагчийн 5 жилийн тэтгэмжид 32.4 сая төгрөг гэх мэт / 1,476.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол,*
- *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг 748.0 сая төгрөгөөр бууруулсан байна.*

2.2 АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД УИХ-ААС БАТЛАГДСАН ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ 45.2 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ, ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БАЙНА

2.2.1 Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагааг Монгол улсын тухайн жилийн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрхийн актууд, төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид нийцүүлэн үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй байхаар төсөвлөж, төлөвлөхөөр зохицуулагдсан байдаг.

2.2.2 Гэтэл аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2025 оны орон нутгийн төсвийн төсөлд төсөл арга хэмжээг зардлын дэлгэрэнгүй тооцоо судалгаагүй, бөөн дүнгээр төлөвлөсөн, батлагдсан орон тооны хязгаарыг нэмэгдүүлсэн зэрэг өмнөх онд төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүйгээр төлөвлөсөн зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 1,000.0 сая төгрөгийн зардлыг төсөл, арга хэмжээгээр салгаж, тооцоо судалгаа хийлгүйгээр бөөн дүнгээр төсөвлөсөн нь төсвийн хяналт сулрах, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.*
- 2. Аймгийн төсвийн 4 байгууллагын орон тоог Сангийн Яамнаас 2025 онд 31 байхаар хянасныг 45.2 хувиар буюу 14-ээр нэмэгдүүлж, 45 болгон, 515.3 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал нэмэгдэхээр төлөвлөсөн байна. Үүнд:*
 - Аймгийн ИТХ: Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолоор ажлын албаны орон тооны хязгаарыг 10 гэж тогтоосныг Сангийн яам хянасан боловч орон тоог 1-ээр нэмэгдүүлж, 35.6 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал,*
 - СХДАА: Сангийн яамнаас 7 орон тоотойгоор хянасан боловч хязгаараас 5-аар нэмэгдүүлж, 12 орон тоотойгоор, 160.7 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал,*
 - ОНӨГ: Сангийн яамнаас 7 орон тоотойгоор хянасан боловч хязгаараас 5-аар нэмэгдүүлж, 12 орон тоотойгоор, 192.0 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал,*
 - ХААГ: Сангийн яамнаас 7 орон тоотойгоор хянасан боловч хязгаараас 3-аар нэмэгдүүлж, 10 орон тоотойгоор, 127.0 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гэх мэт.*
- 3. Аймгийн төсвийн 2 байгууллагын УИХ-аар баталсан суурь урсгал зардлыг үндэслэлгүйгээр болон дэмжих тооцоо, судалгаа, баримтгүйгээр 872.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Үүнд:*
 - Аймгийн ИТХ: Гамшгаас хамгаалах тухай хуулиар аймгийн ИТХ-ын дарга зөвхөн гамшгаас хамгаалах орон нутгийн зөвлөлийг тэргүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгасан бодлогын зөвлөмж, чиглэл өгөх чиг үүрэгтэй атал гамшгаас хамгаалах зардал гэж 100.0 сая төгрөг төлөвлөсөн, урсгал засварын зардлыг 10.0 сая төгрөгөөр буюу нийт 110.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,*

- **Аймгийн ЗДТГ:** Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 800.0 сая төгрөгийг давхардуулан тооцсон, холбогдох тооцоо судалгаа, дэмжих баримтгүйгээр байр ашиглалтын урсгал засварыг 40 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны урсгал засварыг 40 сая төгрөгөөр, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зардлыг 35.0 сая төгрөгөөр буюу нийт **915.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлсэн бол цахилгаан, дулааны зардлын 2025 онд нэмэгдэх **152.4 сая төгрөгийг** дутуу тооцсон байна.

БҮЛЭГ 3. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ЧИГ ҮҮРЭГТ НЬ ҮЛ ХАМААРАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ОНХО, ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨДӨГ ЗӨРЧИЛ ДАВТАГДСАН БАЙНА

3.1 ЗУРАГ ТӨСӨВГҮЙ БОЛОН УЛСЫН ТӨСӨВТ ХАМААРАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ОНХО-ЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН БАЙНА

3.1.1 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны жагсаалтад шинээр хэрэгжиж эхлэх нийт 5,661.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээнээс 2025 онд 5,184.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь хэрэгжиж, 477.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь 2026 он дамжин хэрэгжихээр тусгагдсан байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав/ Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Аймгийн ОНХО-аар хэрэгжүүлэхээр төсөвлөсөн төсөл, арга хэмжээ

(сая төгрөгөөр)

Ангилал	2025 онд хэрэгжиж дуусах			2026 он дамжин хэрэгжих			Нийт		
	Тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
Их засвар	16	3,369.8	3,369.8	1	767.7	290.2	17	4,137.5	3,660.0
Тоног төхөөрөмж	14	1,524.0	1,524.0				14	1,524.0	1,524.0
Нийт	30	4,893.8	4,893.8	1	767.7	290.2	31	5,661.5	5,184.0

Эх сурвалж: Аймгийн 2025 оны төсвийн төсөл

3.1.2 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг, төсөв, үнийн судалгаа нь хийгдээгүй буюу өртөг нь тодорхойгүй 6 төсөл, арга хэмжээнд 1,290.0 сая төгрөгийг, Замын сангийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл, арга хэмжээнд 811.3 сая төгрөгийг тус тус тусгасан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Зураг төсөв, тооцоо судалгаагүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээ

(сая төгрөгөөр)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөвгүй	Үнийн тооцоо судалгаагүй
Орон нутгийн хөрөнгө оруулалт:			
1	Төрийн үйлчилгээний киоск машин		110.0
2	Аймгийн ИТХ-д автомашин худалдан авах		200.0
3	Төрийн албан хаагчдын орон сууц худалдан авах /Шаамар сум/		240.0

4	Соёлын төв, захирагчийн албаны байрны фасад /Орхонтуул, Рашаант тосгон/	280.0	
5	1 дүгээр сургууль, Хэрхийн сургуулийн спорт залны гадна шугам /Мандал сум/	100.0	
6	Цэцэрлэгийн засвар /Зүүнбүрэн сум/	360.0	
	Орон нутгийн хөрөнгө оруулалтын дүн	740.0	550.0
Замын сангийн хөрөнгө оруулалт:			
1	Зүүнбүрэн сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг	251.3	
2	Явган хүний зам, зогсоол гэрэлтүүлэг /Сүхбаатар сумын 8-р баг/	400.0	
3	Хүдэр сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг	160.0	
	Замын сангийн хөрөнгө оруулалтын дүн	811.3	

Эх сурвалж: Аймгийн 2025 оны төсвийн төсөл

3.1.3 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:13.3.3: “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.4 Үнийн тооцоо судалгаа, хүчин чадал, хүрэлцээ, багтаамж нь тодорхой бус “Төрийн албан хаагчдын орон сууц худалдан авах /Шаамар сум/”-д 240.0 сая төгрөг төлөвлөсөн нь нээлттэй сонгон шалгаруулалтаар худалдан авах орон сууц байхгүй суманд тодорхой 1 этгээдэд чиглэсэн хөрөнгө оруулалт болсон байна. Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-дахь “... өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.5 ОНХО-ын төлөвлөгөөнд улсын төсвийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах, байшин барилгыг засварлах зэрэг 8 төсөл, арга хэмжээний нийт 1,212.5 сая төгрөгийг тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.6.6-д “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчин төсвийн хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Улсын төсөвт хамаарах төсөл, арга хэмжээ

(сая төгрөгөөр)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	2025 онд санхүүжих дүн
1	Хэмжилтийн багаж тоног төхөөрөмж / ГХБХБГ/	150.0
2	Лед дэлгэц / Татварын газар/	20.0
3	Хилийн цэргийн алслагдсан ангиудын цахилгааны эх үүсвэр /Хилийн цэргийн 0243-р анги/	120.0
4	Тээврийн хэрэгсэл / Цагдаагийн газар/	30.0
5	Барилгын засвар /Нийгмийн даатгалын газар/	285.0
6	Барилгын фасад засвар / Биеийн тамир, спортын газар/	290.3
7	"Хилчин хотхон" 14 айлын ажилчдын орон сууцны бохирын шугам /Хилийн цэргийн 0101-р анги/	20.0
8	Нэгдсэн эмнэлгийн барилгын засвар / Мандал сум, гүйцэтгэлээр санхүүждэг/	297.2
	Дүн	1,212.5

Эх сурвалж: Аймгийн 2025 оны төсвийн төсөл

3.1.6 Мандал, Сүхбаатар сумдаас бусад бусад сумдын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажилд тус бүр 60.0-120.0 сая төгрөг төлөвлөсөн бол Хүдэр суманд **160.0 сая** төгрөг, Зүүнбүрэн суманд **251.3 сая** төгрөгийг зураг, төсөвгүйгээр төлөвлөсөн байна.

3.2 ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ, ЧИГ ҮҮРЭГТ НЬ ҮЛ ХАМААРАХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

3.2.1 2025 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжин хэрэгжих 1,613.6 сая төгрөгийн өртөг бүхий 10, шинээр хэрэгжих 9,872.9 сая төгрөгийн өртөг бүхий 41 зэрэг нийт 11,486.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-т харуулав./ Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа

(сая төгрөгөөр)

Ангилал	Өмнөх оноос шилжих			Шинэ			Нийт		
	Тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
Барилга байгууламж	9	5,767.6	1,388.6	10	3,893.8	3,107.5	19	9,661.5	4,496.1
Их засвар	1	405.0	225.0	10	4,439.9	3,841.6	11	4,844.9	4,066.6
Тоног төхөөрөмж				6	1,620.0	1,342.0	6	1,620.0	1,342.0
Зураг төсөв				14	1,281.8	1,281.8	14	1,281.8	1,281.8
Баяр наадам				1	300.0	300.0	1	300.0	300.0
Нийт	10	6,172.6	1,613.6	41	11,535.5	9,872.9	51	17,708.2	11,486.5

Эх сурвалж: Аймгийн 2025 оны төсвийн төсөл

3.2.2 ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулсан боловч төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, иргэд, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, санал авч, эрэмбэлэх ажил бүрэн хийгдээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.1¹, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1², 7.4³, 7.5⁴ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2.3 2025 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт **1,519.9** сая төгрөгийн өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2⁶ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Уламжлалтын тасгийн тоног төхөөрөмж (Аймгийн нэгдсэн эмнэлэг)”,
- 349.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сүрьеэгийн тасгийн их засвар (Аймгийн нэгдсэн эмнэлэг)”,
- 1,100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хавдрын тасгийн засвар, тоног төхөөрөмж (Аймгийн эгдсэн эмнэлэг)”,
- 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хараа голын гүүрний засвар (Мандал сум, Түнхэл тосгон)”

3.2.3 Зураг, төсөв, үнийн тооцоо судалгааг урьдчилан хийлгээгүй 11 төсөл, арга хэмжээнд нийт **3,017.6** сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3⁸ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

¹ Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна.

² Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

³ Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

⁴ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

⁵ ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, ...

⁶ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх.

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

Хүснэгт 5. Зураг, төсвийг урьдчилан хийлгэлгүйгээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ
(сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн
		Эхлэх	Дуусах		
1	Инженерийн шугам сүлжээний шинэчлэл /Алтанбулаг сум/	2025	2025	500.0	500.0
2	Төрийн албан хаагчдын байр барих /Баруунбүрэн сум/	2025	2026	450.0	280.0
3	Дулааны шугамын засвар, шинэчлэлтийн ажил /Сүхбаатар сум, 4-р баг/	2025	2025	400.0	400.0
4	Дулааны шугамын шинэчлэл /Түшиг сум/	2025	2025	100.0	100.0
5	Гүний худаг гаргах /Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2025	2025	67.7	67.7
